НЗД-ын 1993 оны 1282-р захирамжаар хүчингүй болсон!

УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

# ТОГТООЛ

198 2 оны 2 дугаар сарын 2 ны өдөр

Дугаар I4

Улаанбаатар хот

## АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ НЭЭЖ АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

I.ЗХУ-ын тусламжаар орон сууцны Ш хороололд барьж ашиглалтад орж байгаа ахуйн үйлчилгээний төвд дараах үйлчилгээний салбаруудыг шинээр нээж ажиллуулсугай.Үүнд:

-Гэр ахуйн цахилгаан хэрэгслэл, биеийн тамирын барааг хөлсөөр олгох үйлчилгээ
-Радио телевизорын засвар
-Гэр ахуйн цахилгаан хэрэгслэлийн засвар
-Гутал засвар
-Гутал захиалгын тасаг
-Хүүхэд, эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувцас захиалгын тасаг

2.Ахуйн үйлчилгээний удирдах газар /н.Содном/-т даалгах нь:

а/дээрх үйлчилгээний төвд нэхмэл сүлжмэлийн тасгийг шилжүүлэн байрлуулах.

б/ахуйн үйлчилгээний төвд нээгдэж байгаа цэг салбаруудын бэлтгэлийг бүрэн хангаж, энэ оны 2-р сарын эхний хагаст багтаан ашиглалтад оруулах.

в/шинээр ашиглалтад орж байгаа ахуйн үйлчилгээний

төвийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авч цаашдын ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах.

3.Дээрхи үйлчилгээний төвийн 2-р давхар, I-р давхарын эмэгтэйчүүдийн хувцас захиалгын цехийн байрыг тусгай үйлчилгээнд зориулан НААҮ яамны зохион бүтээх товчоонд түрээсээр ашиглуулахыг Ахуйн үйлчилгээний удирдах газар/Н.Содном/-т зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ